



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

**Монголын Бүх Ард Түмний Спортын XVI
наадмын шигшээ тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэг, Монгол улсын засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 183 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Монголын Бүх Ард Түмний XVI наадам"-ын шигшээ тэмцээн нэгдсэн зааврын дагуу 2025 оны 09 дүгээр сарын 15-наас 21-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдах тул дүүргээс шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулсугай.

2.Шигшээ тэмцээний зардалд 70,662,400 (Далан сая зургаан зуун жаран хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг нэмэлт санхүүжүүлтийн данснаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ *Э.Батхүү* Э.БАТХҮҮ



1292001111